

Бэлтгэснээр адислалууд ирдэг

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Солт Лейк хотын Чуулганы Төвд цуглараад байгаа ах нар та бүхнийг хараад сэтгэл догдлон хөдөлж байна. Дэлхий даяар Сүмийн мянга мянган байруудад Бурханы бусад санваартнууд та бүхэн энэ чуулганыг хиймэл дагуулын төхөөрөмжөөр дамжуулан хүлээн авч байгааг бодоход гайхамшигтай байна. Та бүхэн янз бүрийн үндэстний, олон хэлийн хүмүүс ч, биднийг нягт холбодог нэгэн нийтлэг зүйл байдаг. Бид бол санваарыг эзэмшиж, Бурханы нэрээр ажиллах ариун итгэмжлэлийг өөртөө хүлээсэн хүмүүс. Биднээс асар их зүйлийг хүсэн хүлээдэг.

Диконоор дөнгөж томилогдоод байхдаа санваартны хуралд сууж, “Бурханы хөвгүүд ээ, ирцгээ” дууллыг нээлтийн дуугаар дуулж байсан нь бага насны минь хамгийн тод томруун дурсамжуудын нэг юм. Өнөө орой би тэрхүү онцгой дууллын утгыг эргэн санахыг хүсч байна. Санваар авсан, Бурханы хөвгүүдээ бүгдээрээ ирцгээ; дуудлагуудаа анхаарч, үүрэг хариуцлагаа онцгойлон, Их Эзэн Есүс Христээ дагацгаая.

20 жилийн өмнө хүүхдүүд, Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтүүдийн Сүмийн гишүүн гэсэн сэдвээр үг хэлсэн ариун ёслолын нэг цуглаанд би суусан юм. Тэдгээр охид хөвгүүд Их Эзэний болон бусдын төлөө үйлчлэлд бэлтгэгдэж байгаагаа харуулсан. Дуу хөгжим нь сайхан байсан бөгөөд тэд өөрсдийн хэсгийг чадварлагаар уншихад нь тэнгэрээс сүнс илгээгдсэн юм. Тэр үед 11 настай байсан миний нэг ач хүү энэ хөтөлбөрт Анхны Үзэгдлийн тухай ярьж билээ. Хөтөлбөрийн дараа түүнийг ээж аав, эмээ өвөө дээрээ хүрч ирэхэд нь би “Томми, чамайг номлогч болоход бараг бэлэн байгаа гэж би бодож байна шүү” гэж түүнд хэлсэн юм. Ач хүү маань, “Арай болоогүй ээ, Надад сурах зүйл зөндөө байна” гэж билээ.

Үүнээс хойших жилүүдэд үнэнч хичээнгүй, хариуцлагатай эцэг эх, сүмийн багш нар, зөвлөхүүдийн ачаар Томми үнэхээр сурч чадсан юм. Тэр зохих насанд хүрээд номлолд үйлчлэхээр дуудагдаж, туйлын хүндэтгэлтэйгээр үйлчилсэн билээ.

Залуу эрэгтэйчүүд ээ та бүхнийг номлогчоор үйлчлэхэд бэлтгэхийг би сануулж байна. Ашигтай хичээлүүдийг судлах, зохистой байдлаар амьдрахад тань туслах олон арга хэрэгсэл та нарт байдаг. Ийм нэгэн хэрэгсэл бол Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын удирдлага дор хэвлэгдсэн *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* нэртэй жижиг товхимол юм. Энэ товхимол Сүмийн удирдагчдын сургаал, бүтээлүүдэд болон судруудад байдаг жишгүүдийн тухай өгүүлдэг. Эдгээр жишгүүдийг чанд сахих нь Тэнгэрлэг Эцэгийн адислалууд болон Түүний Хүүгийн удирдамжийг бид бүгдэд авчирдаг. Түүнээс гадна залбиралтайгаар авч хэлэлцэн, нягт няхуураар бэлтгэсэн хичээлийн гарын авлагууд бий. Гэр бүлүүдэд сайн мэдээний зарчмуудыг заадаг гэр бүлийн үдэш байдаг. Та нартай хуваалцах өргөн мэдлэг, хичээнгүй зүтгэлтэй багш нарын заадаг семинарт та нар бараг бүгдээрээ оролцох боломжтой.

Ариун сүмийн гэрлэлтэд, номлолд бэлтгэж эхэл. Зөв зохистой болзоо энэхүү бэлтгэлийн нэг хэсэг юм. Болзоонд явахыг хүлээн зөвшөөрдөг ёс заншилтай оронд амьдардаг бол 16 нас хүртлээ болзоонд битгий яв. Арван хэдэн настай хүүхдүүд бүгдээрээ болзоонд явах шаардлагатай биш, зарим нь үүнийг хүсэх ч үгүй биз. Болзоонд явж эхлэхдээ хэсэг бүлгээрээ эсвэл өөр хосуудтай хамтдаа яв. Болзож буй хүмүүсээ эцэг эхтэйгээ заавал уулзуулж, танилцуулж бай. Болзоонд явах нь гэрлэлтийн бэлтгэл учраас зөвхөн өндөр жишигтэй хүмүүстэй болз.

Болгоомжтой бай, уруу таталттай тулгарахгүй, сайн орчинтой газар оч.

Нэгэн ухаалаг эцэг хүүдээ хандан, “Хэрэв чи байх ёсгүй газар оччихсон байх юм бол, шууд гараад яв!” гэж хэлжээ. Энэ бол бид бүгдэд сайн зөвлөгөө болох юм.

Их Эзэний үйлчлэгчид бид өөрсдийгөө болон Тэнгэрлэг Эцэгээ хүндэлдгээ

харуулахаар зөв зохистой хувцаслах хэрэгтэй гэж байнга зөвлөсөөр ирсэн.

Хувцасласан байдал чинь чиний ямар хүн болохыг бусдад хэлж өгдөг. Энэ нь бас та нарт бусад хүмүүс хэрхэн хандахад олонтоо нөлөөлдөг. Та нарын болон эргэн тойрон дахь хүмүүсийн чинь хамгийн шилдэг зан төлөвийг харуулах байдлаар хувцасла. Хувцас болон биеийнхээ ил харагдах болон харагдахгүй хэсэгт шивээс хийлгэх, цоолох зэрэг гаж буруу зүйлсээс зайлсхий.

Хүн бүрд сайн найз хэрэгтэй. Найз нөхөд чинь та нарын бодол санаа, зан төлөвт их нөлөө үзүүлдэг. Мөн үүн лүгээ чи ч бас тэдэнд нөлөөлдөг. Та нарын эрхэмлэдэг зүйлс найз нарынхтай чинь тохирч байвал та нар бие биеэ дэмжиж, бэхжүүлж чадна. Хүн бүртэй нинжин сэтгэл, хүндэтгэлээр харилцаж бай. Гишүүн биш олон найз нар аа Сүмийн үйл ажиллагаанд урьснаар Сүмд орсон байдаг.

“Шударга байдал хамгийн сайн дүрэм”¹ гэсэн байнга хэлэгддэг нэгэн зүйр үг үнэхээр үнэн юм. Хожмын Үеийн Гэгээнтэн залуу эрэгтэй заадаг болон итгэдэг зүйлийнхээ дагуу амьдардаг. Тэр бусдад болон өөртөө шударга ханддаг. Тэр Бурханд шударга ханддаг. Сурсан юмыг сураар боож болдоггүй гэдэг шиг зуршил болсон байдлаар аливаад шударга байж чаддаг. Хэцүү шийдвэр гаргах хэрэгтэй болсон үед тэр хэзээ ч “Бусад хүмүүс юу гэж бодох бол?” гэж өөрөөсөө асуудаггүй харин, “Би өөрийнхөө тухай юу гэж бодвол зохих вэ?” гэж асуудаг.

Зарим хүмүүс шударга байдлынх нь жишгийг гутаах уруу таталттай учирдаг.

Миний сурдаг байсан их сургуулийн бизнесийн хуулийн ангийн нэг залуу хичээл дээрх ярилцлагад огт бэлтгэдэггүй байсныг санаж байна. “Тэр яаж эцсийн шалгалтандаа тэнцэх юм бол?” гэж би дотроо боддог байв.

Өвлийн нэг өдөр тэр нүцгэн хөлөндөө сандаал өмсөн, төгсөх шалгалтаа өгөхөөр ангид орж ирэхэд бид учрыг нь мэдсэн юм. Би ихэд гайхаж шалгалт эхлэх үед

түүнийг харж суулаа. Бүх номнуудаа шалаар дүүрэн тавьсан байлаа. Тэр сандаалаа хөлнөөсөө сугалаад, дадлага хийж, глицерин түрхэж сургуулилсан хөлийнхөө хуруугаар шалан дээрх номнуудын нэгнийх нь хуудсуудыг чадварлагаар эргүүлж, шалгалтын асуултуудын хариуг харж байлаа.

Бизнесийн хуулийн хичээлээр тэр ангийнхнаас хамгийн сайн дүн авсан оюутнуудын нэг нь байлаа. Гэвч тэрээр зохих шангаа хүртсэн юм. Түүнийг ерөнхий шалгалтад бэлтгэж байх үед энэ ангийн декан анх удаагаа, “Энэ жил бид хуучин уламжлалаа орхиод, бичгийн шалгалтын оронд амаар шалгалт авах боллоо” гэв. Нөгөөх хөлийн хуруугаараа гайхалтай чадварлаг сургуулилсан залуу маань энэ удаа асуултуудад хариулж чадаагүйдээ ихэд ичиж, шалгалтандаа унав.

Та нарын ярьдаг зүйл, хэлдэг үгс чинь зан төлөвийн чинь талаар ихийг илэрхийлдэг. Эргэн тойрон дахь хүмүүсээ сэтгэл санаагаар дэмжиж, туслах үг хэллэгийг хэрэглэ. Гутаан доромжилсон, бүдүүлэг үг хэллэг, зохисгүй хошин шог нь Их Эзэнийг гомдоодог. “Чи өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурд”² гэж Их Эзэн хэлсэн байдаг.

Тэнгэрлэг Эцэг маань биднийг “ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай”³ зүйлсийг эрэлхийлэхийг зөвлөсөн билээ. Уншиж, сонсож, үзэж байгаа бүхэн чинь чамд нөлөөлөх болно.

Ялангуяа порнограф бүр ч аюултай, донтуулдаг зүйл юм. Порнографыг шохоорхон сонирхох нь хүчтэй зуршил болж, улмаар бүр илүү бузар зүйл болон бэлгийн харилцааны нүгэлд хөтөлдөг юм. Порнографтаас бүх хүч чадлаараа зайлсхий. Захиас нь Тэнгэрлэг Эцэгийн жишигт нийцэхгүй тохиолдолд киноноос гарч яв. Телевизороо унтрааж, радиогийн сувгийг өөрчлөхөөс бүү ай. Ямар нэг кино, ном, үзвэрийн бусад хөтөлбөр зохистой эсэхэд эргэлзэж байгаа бол бүү үз, бүү

унш, бүү оролц.

Төлөөлөгч Паул, “Та нар өөсдөө Бурханы сүм бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юмуу?. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн”⁴ гэж хэлжээ. Ах дүү нар минь, өөрсдийнхөө сүмийг цэвэр ариунаар нь байлгах нь бидний үүрэг юм.

Аюултай хар тамхи, жороор авдаг хүчтэй эмийг буруугаар хэрэглэх, архи, кофе, тамхи зэрэг бүтээгдэхүүнийг хэрэглэх нь бие бялдар, оюун санаа, сүнсний эрүүл мэндийг чинь сүйтгэх болно. Аль ч төрлийн согтууруулах ундаа сүнс болон биенд чинь хортой. Тамхи чамайг боолчилж, уушгийг чинь муудуулж, амьдралыг чинь богиносгодог.

Дуу хөгжим биднийг Тэнгэрлэг Эцэгт ойртуулж чадна. Дуу хөгжмийг бас сурч боловсрох, гэгээрэх, сүнслэг нөлөөн дор байх, эв нэгдлийг бий болгоход хэрэглэж болно. Гэхдээ энэ нь хурд, хэмнэл, эрч хүч болон үгнээсээ болоод бидний сүнслэг мэдрэмжийг бууруулдаг. Та нар оюун санаагаа зохисгүй дуу хөгжмөөр дүүргэж үнэхээр болохгүй.

Бэлгийн харилцааны дотно байдал эмзэг ариун учраас Их Эзэн биднийг гэрлэхээсээ өмнө цэвэр ариун, өөрийгөө хянах чадвартай байж, гэрлэснийхээ дараа хань ижилдаа чин үнэнч байхыг шаарддаг. Болзооныхоо үед болзож буй хүнтэйгээ хүндэтгэлтэйгээр харьцаж бай. Тэр мөн чамайг адилхан хүндлэх ёстой. Нүгэл үйлдсэний дараа гашуун нулимс заавал урсдаг.

Сүмийн ес дэх Ерөнхийлөгч Давид О.МкКей, “Цэвэр ариун бодолтой байхыг би та нараас хичээнгүйлэн гуйж байна” гэж хэлжээ. Тэгээд тэрээр: “Бүх үйлдлийн өмнө бодол санаа байдаг. Хэрэв бид үйлдлээ хянахыг хүсч байгаа бол эхлээд бодол санаагаа хянах хэрэгтэй” гэж хэлсэн нь яах аргагүй үнэн юм. Ах нар аа оюун санаагаа зөв бодлоор дүүргэ, тэгвэл үйлс чинь зөв зохистой байх болно. Теннисийн

нэгэн яруу найрагт Ноён Галахад: “Зүрх сэтгэл минь цэвэр ариун учраас миний хүч чадал арван хүнийхтэй тэнцүү юм”⁷ гэснийг та нар давтан хэлэх боломжтой байх болтугай.

Саяхан өсвөр насныхны бэлгийн харилцааны тухай нэгэн илтгэлийг бичсэн зохиогч нь нийгэм өсвөр насныханд холимог мэдээлэл: зар сурталчилгаа, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн дамжуулдаг “бэлгийн харилцаа бол байж болох зүйл бас хийх ёстой зүйл” гэсэн хүчтэй сэтгэгдэл төрүүлэх мэдээнээс” бүрдэж байна гэсэн дүгнэлтийг судалгаандаа хийжээ. Энэ нь мэргэжлийн хүмүүсийн сэрэмжлүүлэг болон эцэг эхчүүдийн хүсэлтийг сонсоход хэцүү болгодог байна “Цэвэр ариун байгтун та нар”⁸ гэж Их Эзэн эрс шулуун, тодорхой тунхагласан нь олон нийтийн бүх мэдээллийн хэрэгслээс тод ялгаран харагддаг.

Уруу таталт ирэх бүрд, “Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм”⁹ гэсэн Төлөөлөгч Паулын ухаалаг зөвлөгөөг санагтун.

Сүмийн Гишүүнээр батлагдахад, чи Ариун Сүнстэй байнгын хамтрагч байх тэрхүү эрхийг хүлээн авлаа. Тэр чамд сайн сонголтуудыг хийхэд тусалж чадна. Сорилт бэрхшээл, уруу таталттай учрах үедээ чи ганцаар байхгүй. Залбирал бол Сүнсний хүчинд нэвтрэх эрхийн бичиг мөн гэдгийг сана.

Хэрэв хэн нэг нь замдаа бүдэрвэл, буцах зам байдаг юм шүү. Энэ үйл явцыг наманчлал гэдэг. Аврагч маань адислалын энэхүү бэлгийг та бидэнд боломжтой болгохын тулд амь насаа өргөсөн юм. Наманчлах зам нь хэдийгээр хэцүү ч, амлалт нь үнэн бодитой юм: “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан

болно.”¹⁰

Мөнх амьдралаа аз туршсан байдалд бүү оруул. Бурханы зарлигуудыг сахь. Хэрэв чи нүгэл хийсэн бол, хэдийчинээ эрт буцах замаа эхэлнэ, өршөөлийн гайхамшгаар ирэх тэрхүү амтлаг амар амгалан, баяр баяслыг төдийчинээ хурдан олох болно. Аз жаргал нь Их Эзэн чамаас хүссэн тэр замаар амьдарснаар, Бурханд болон бусдад үйлчилснээр ирдэг.

Сүнсний хүч чадал амин хувиа үл хичээх үйлчлэлээс олонтоо ирдэг. Хэдэн жилийн өмнө, би тухайн үед Калифорнийн номлол гэж нэрлэгддэг байсан газар очихдоо Жорж муж улсаас ирсэн нэгэн залуу номлогчтой ярилцлага хийсэн билээ. Би түүнд: “Чи долоо хоног бүр гэр уруугаа аав ээждээ захидал явуулдаг уу?” гэж асууснаа санаж байна.

“Тэгдэг ээ, Монсон Ахаа” гэж тэр залуу хариулсан.

Дараа нь би түүнээс, “Чи гэрээсээ захиа авах дуртай юу?” гэж асуув.

Тэр хариулсангүй. Удаан дуугүй байсны дараагаар би, “Чи хамгийн сүүлд хэзээ гэрээсээ захиа авсан бэ?” гэж лавлан асуув.

“Би гэрээсээ нэг ч захиа аваагүй. Аав маань дөнгөж дикон, ээж Сүмийн гишүүн биш. Тэд надаас номлод битгий яваач гэж гуйдаг байсан. Намайг номлолд явах юм бол тэд надад захиа огт бичихгүй гэж хэлсэн. Би яах ёстой вэ? Монсон ах аа” гэж чичирхийлсэн дуугаар тэр хариулж билээ.

Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан чимээгүйхэн залбирлаа: “Танд үйлчлэхийн тулд бүх зүйлээ золиосолсон, Таны энэ залуу үйлчлэгчид би юу гэж хэлэх вэ?” Тэгтэл илчлэлт ирэх нь тэр. Би, “Ахлагч аа, номлолынхоо бүх үед долоо хоног бүр гэртээ, аав ээждээ захидал бич. Юу хийж байгаагаа тэдэнд хэл. Тэдэнд ямар их хайртайгаа хэл, мөн тэгээд тэдэнтэй гэрчлэлээ хуваалц” гэж хэлэв.

“Тэгвэл аав ээж надад захиа бичих болов уу?” гэж тэр асуулаа.

“Тэгвэл тэд чамд захиа бичнэ шүү дээ” гэж би хариулж билээ.

Бид салаад, би цаашаа явсан. Хэдэн сарын дараа би Өмнөд Калифорнид гадасны чуулганд оролцож байх үед нэг залуу номлогч над дээр хүрч ирээд, “Монсон ахаа, та намайг таньж байна уу? Би номлолын талбарт байсан эхний есөн сарын турш аав ээжээсээ нэг ч захиа аваагүй нөгөөх номлогч байна. Та надад, “Ахлагч аа, долоо хоног болгон гэртээ захиа явуул, аав ээж чинь чамд захиа бичих болно” гэж хэлж билээ гээд тэр надаас, “Ахлагч Монсон, та тэр амлалтаа санаж байна уу?” гэж асуув.

Би саналаа. “Тэгээд гэрээсээ захиа авсан уу?” гэж асуув.

Тэрээр халааснаасаа резинээр ороосон боодолтой бөөн захидал гаргаж ирээд, дээрээс нь нэгийг авч, “Би аав ээжээсээ захиа авсан шүү!” гэж билээ. Ээжээс ирсэн энэ захиаг сонс доо: “Хүү минь, бид чиний захиаг унших маш их дуртай. Бид номлогч хүүгээрээ бахархаж байна. Юу болсон гээч? Аав чинь пристээр томилогдсон. Тэр надад баптисм хүртээхээр бэлтгэж байгаа. Би номлогч нартай уулзаж байгаа. Тэгээд одоогоос нэг жилийн дараа чамайг номлолоо дуусгахаар бид Калифорнид очихыг хүсч байгаа, Яагаад гэвэл, Их Эзэний ариун Сүмд орсноор бид чамтай хамт мөнхийн гэр бүл болохыг хүсэж байна.” Энэ залуу номлогч, “Монсон ах аа, Тэнгэрлэг Эцэг залбиралд үргэлж хариулж, Төлөөлөгчдийн амлалтыг биелүүлдэг үү?” гэж асуув.

“Чиний харуулсан шиг ийм итгэл хэн нэгэнд байвал, Тэнгэрлэг Эцэг ийм залбирлуудыг сонсож, Өөрийн арга замаар хариулдаг” гэж би хэлсэн.

Цэвэр гар, ариун зүрх, мөн дуулгавартай оюун сэтгэл тэнгэрт хүрсэн юм. Тэнгэрээс илгээсэн адислал тэр номлогчийн зүрх сэтгэлийн даруухан атлаа гал цогтой залбиралд хариулсан юм.

Ах нар аа, бид ч бас ийм байдлаар амьдарч, тэнгэртэй харилцан ийм байдлаар адислагдахын төлөө би бүх бэлгийг Өгөгч, бүр Есүс Христийн нэрээр залбирч байна. амен.

ЭШЛЭЛ

1. "Come, All Ye Sons of God," *Hymns*, no. 322.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (Товхимол, 2001), 24, 25.
3. Мигель де Сервантес, in John Bartlett, comp., *Familiar Quotations*, 14th ed. (1968), 197.
4. Египетээс Гарсан нь 20:7.
5. Итгэлийн Тунхаг 1:13
6. 1 Коринт 3:16-17.
7. Alfred Lord Tennyson, in *Familiar Quotations*, 647.
8. Сургаал ба Гэрээ 38:42.
9. 1 Коринт 10:13
10. Исаиа 1:18.

